

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны...сарын...өдөр

Дугаар... /....

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг, Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ахуйн бохир ус зайлуулах цэгийг ус тусгаарлагчаар тусгаарлаж, тохижуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйгээр хангах ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар /Ш.Мягмар/, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газар /Д.Ганцэцэг/-т, хяналт тавьж ажиллахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга, Мэргэжлийн хяналтын байгууллага, Сав газрын захиргаа, Аймаг, нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Байгаль орчны сайд, Сангийн сайдын 1995 оны 169/171 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД

Н.ЦЭРЭНБАТ

Д.САРАНГЭРЭЛ

## АХУЙН БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ЦЭГИЙГ УС ТУСГААРЛАГЧААР ТУСГААРЛАЖ, ТОХИЖУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь ахуйн бохир ус зайлуулах цэгийг /цаашид “цэг” гэх/ ус тусгаарлагчаар тусгаарлаж, тохижуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Ус ашиглагч тухайн цэгээс хөрсөнд ус нэвчүүлэхгүй байх найдвартай байдлыг хангана.

1.3. Ус ашиглагч ус тусгаарлагчаар тусгаарлаж, тохижуулсан цэгийг ашиглалтад оруулахын өмнө мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

1.4. Тухайн сум, дүүргийн байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын байцаагч цэгийн ашиглалтад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулна.

1.5. Байгаль орчны газар цэгийн талаарх мэдээллийг усны нэгдсэн мэдээллийн санд жил бүр оруулна.

### Хоёр. Цэгийн тохижуулалтад тавих шаардлага

2.1 Цэгийг жорлонтой аль болох ойролцоо нэг дор байхаар тооцоолон тусад нь байрлуулна.

2.2 Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь Нүхэн жорлон, угаадасны нүх MNS 5924:2015 стандартын дагуу тохижуулалтыг гүйцэтгэж, тээврийн хэрэгслийн зогсоолыг хатуу хучилттай болгож, гадаргын ус зайлуулах суваг татсан байна.

2.3. Цэгийн гадна талыг гэрэлтүүлж, цэгээс гэр, сууц, ажлын байр хүртэл зам тавьж, цэгийн амсрыг хур борооны ус нэвтрэхээс хамгаалсан тагтай, сараалжтай болгож тохижуулна.

2.4. Цэгийн орчны нөхцөлөөс хамааруулан эргэн тойрныг тэгшлэх, хур, борооны ус, чийг шүүрч нэвчихээс сэргийлж, хатуу хучилт хийнэ.

2.5. Цэгийн нүхний таглааны дунд хэсэгт түүний талбайн дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээний бохир ус соруулах, ухаж лайдах зориулалтын таг байрлуулж, агааржуулалтын яндан хоолой гаргаж өгнө.

### Гурав. Цэгийн доторлогоонд тавих шаардлага

3.1 Цэгийг бетон, төмөр бетон, геомембран болон бусад ус үл нэвчих материалаар доторлоно:

3.1.1 Бетон, төмөр бетон доторлогооны шаардлагыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 107 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Усны барилга, байгууламжийн бетон ба төмөр бетон бүтээц” /БНБД33-06-09/-ийн дагуу хангасан байна.

3.1.2 Энэхүү журмын 3.1-т зааснаас өөр Монгол Улсын стандартчилалын байгууллагаар баталгаажсан ус нэвчихгүй материал ашиглаж болно.

3.3 Хоногт 5 шоометрээс их бохир ус хуримтлагдах цэгийн доторлогоог батлагдсан зураг төслийн дагуу хийнэ.

### **Дөрөв. Бохир усыг татан зайлуулах**

4.1. Цэгийн эзэлхүүний 70-80 хувь дүүрсэн үед зориулалтын техник, хэрэгслээр соруулах буюу суллаж, цэгийн ариутгал хийж дахин ашиглана.

4.2. Усны тухай хуулийн 13.1.4-д заасны дагуу Сум, дүүргийн Засаг даргын тогтоосон хаягдал ус зайлуулах цэгт хаяна.

4.3. Цэгт хог хаягдал, хоолны үлдэгдэл хаяхыг хориглоно.

4.4. Дахин ашиглах боломжгүй цэгийн хөрсийг зайлуулж, халдваргүйжүүлэлт хийн, эрүүл хөрсөөр дүүргэж ариутгана.

4.5. Цэг, түүний орчимд шаардлагатай тохиолдолд хөрсний бохирдлын шинжилгээ хийлгэж, халдваргүйжүүлэх арга хэмжээг сум, дүүргээс жил бүр тогтоосон хугацаанд зохион байгуулна.

4.6. Цэгийн гэнэтийн осол, эвдрэлийн улмаас ус ашиглагч хаягдал усыг цэвэрлэхгүйгээр хаях болсон тохиолдолд Усны тухай хуулийн 24.3-т заасны дагуу арга яаралтай арга хэмжээг авна.

### **Тав. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

5.1 Энэхүү журмын нөхцөл, шаардлагыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн 6.15-д заасан хариуцлагыг ногдуулна.